



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 343

Улаанбаатар хот

Орон сууц хувьчлах товчоо  
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Орон сууц хувьчлах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, “Орон сууц хувьчлах товчооны ажиллах журам”-ын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн орон сууц хувьчлах товчоог хавсралтад заасан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

2. Орон сууц хувьчлах тухай хууль тогтоомж, “Орон сууц хувьчлах товчооны ажиллах журам”-ыг мөрдөж ажиллахыг товчоонд үүрэг болгосугай.

3. Товчооны үйл ажиллагааны зардлыг зохих журмын дагуу тооцож, төсөвт тусган санхүүжүүлэхийг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөрт зөвлөсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 68 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б. Гавваа

Ц.НЯМ-ОСОР


Б.ГАВАА



0002070



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын 2018 оны 07 дугаар сарын 06-ны  
өдрийн 343 дугаар тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦ ХУВЬЧЛАХ  
ТОВЧООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Товчооны дарга

Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд  
Захирагчийн ажлын албаны дарга

Орлогч дарга

Улаанбаатар хотын Орон сууц, нийтийн аж  
ахуйн удирдах газрын дарга

Нарийн бичгийн дарга

Улаанбаатар хотын Орон сууц, нийтийн аж  
ахуйн удирдах газрын орон сууц хувьчлах  
асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Налайх хотын Захирагч

Багануур хотын Захирагч

Багахангай хотын Засаг дарга

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны  
Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга

----- о О о -----